



## НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 7/58

Улаанбаатар хот

### Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөвлөлийг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм” 33 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны “Журам батлах тухай” 129 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ёс зүйн зөвлөлийн дүрмийг хоёрдугаар, зөвлөлийн ажиллах журмыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн гишүүдийн хурлын бэлтгэл, зохион байгуулалтыг чанарын өндөр түвшинд хийж, хурлаас гарсан шийдвэрийг шуурхай хэрэгжүүлэх, шийдвэрийг байгууллагын албан хаагч нарт тухай бүр мэдээлж ажиллахыг Ёс зүйн зөвлөл (Д.Дэлгэрбаяр)-д даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Э.Энхжаргал)-т даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хороо болон дүрэм батлах тухай” 2019 оны А214 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЦЭНД-АЮУШ



Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын  
2023 оны 04. дугаар сарын 11. -ны өдрийн  
158 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН  
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

№	Бүрэлдэхүүн	Нэр	Албан тушаал
1	Зөвлөлийн дарга	Д.Дэлгэрбаяр	Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч
2	Гишүүн	Т.Лхагвабуян	Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын байцаагч
3	Гишүүн	Ц.Сонгиносүрэн	Хувийн хэвшлийн ортоой эмнэлэг, сувилал эмийн сангийн мэдээ, тайлан хариуцсан ахлах мэргэжилтэн
4	Гишүүн	Н.Мэндсайхан	Халдварт бус өвчний хяналт, сэргийлэлт, эрт илрүүлэгийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
5	Зөвлөлийн нарийн бичиг	М.Галбадрах	Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын байцаагч

Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын  
2023 оны 0% дүгээр сарын 10 -ны өдрийн  
158 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Нийслэлийн Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч (цаашид “төрийн албан хаагч” гэх)-ийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоож хэвшүүлэх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол мэдээллийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Хөдөлмөрийн тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 122 дугаар тогтоол нь Нийслэлийн Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн эрх зүйн үндэс мөн.

1.3. Нийслэлийн Эрүүл мэндийн газар энэхүү дүрмийг дагаж мөрдүүлэн, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлж ажиллана.

### Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэхүү дүрэм нь Нийслэлийн Эрүүл мэндийн газрын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэгэн адил хамаарна.

### Гурав. Нэр томьёоны тодорхойлолт

Энэхүү дүрэмд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1. "Ашиг сонирхлын зөрчил" гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг;

3.2. "Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал" гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн, ах, дуу, хамаатан садан гэх мэт олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг;

3.3. "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил" гэж төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг.

## **Дөрөв. Ёс зүйн хэм хэмжээ**

4.1 Нийслэлийн эрүүл мэндийн газрын төрийн захиргааны болон үйлчилгээний ажилтан нь үйл ажиллагаандaa дор дурдсан хэм хэмжээг мөрдөж ажиллана.

4.1.1. Үзэл бодол, зан суртахуун, үг, үйлдлээрээ Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулсан хууль ёсыг эрхэмлэн дээдлэх зарчмыг илэрхийлэн сахина;

4.1.2. Шударга ёсыг дээдэлж, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна;

4.1.3. Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэнэ;

4.1.4. Ард түмэндээ чин сэтгэлээс үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдэлнэ;

4.1.5. Албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээдэг байна;

4.1.6. Албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа нөлөөллөөс ангид байна;

4.1.7. Захирах, захирагдах ёсыг сахин биелүүлнэ.

## **Тав. Төрийн албан хаагчид тавих ёс зүйн шаардлага**

**5.1 Төрийн албан хаагч нь төрийн бодлого, байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээ үзүүлэхдээ дор дурдсан ёс зүйн шаардлагыг биелүүлэх;**

5.1.1. Үзэл бодол, зан суртахуун, үг, үйлдлээрээ Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулсан хууль ёсыг эрхэмлэн дээдлэх зарчмыг илэрхийлэн сахих ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:

5.1.1.а. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж байгаа соёл, дэг журам, дүрэм, зааврыг чанд баримтлах;

5.1.1.б. Хууль зөрчсөн, авлига авсан, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;

5.1.1.в. Харьяалах дээд шатны албан тушаалтыг хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээллээр хангах;

5.1.1.г. Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх;

5.1.1.д. Төрийн болон байгууллагын, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хамгаалах;

5.1.1.е. Удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй үр дагавар, сөрөг талыг урьдчилан анхааруулж байх.

**5.1.2. Шударга ёсыг дээдэлж, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ёс зүйн хэм хэмжээний хүрээнд;**

5.1.2.а. Өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орон, ард түмнийхээ эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас

татгалзах;

5.1.2.б. Төрийн хөрөнгө, орлогын байдал, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаар эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдээлэх;

5.1.2.в. Төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх, эд хөрөнгө, техник хэрэгслийг зөв, гамтай, цэвэр нямбай ашиглах;

5.1.2.г. Албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд хууль бусаар давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохигох, амлалт өгөх, тэднээс бэлэг, шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, бусад хангамж эдлэхгүй байх;

5.1.2.д. Хамаарал бүхий этгээдийн ажиллаж байгаа байгууллага, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, албаны нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг цээрлэх.

5.1.2.е. Иргэдийг яс үндэс, хүйс, арьсны өнгө, боловсрол, мэргэжил, гадаад, үзэмж, албан тушаал, нэр хүндээр ялгаварлан хандах, үл тоомсорлосон сэтгэгдэл төрүүлэхүйц үйлдэл хийх, хүнд суртал гарган чирэгдүүлэх, танил тал харж, хувийн ашиг сонирхлын үүднээс хандах, бусдын нөлөөнд автах, аливаа иргэн болон байгууллагын эрх ашигт давуу байдал үүсгэхгүй байх;

5.1.2.ё. Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан олон нийтийн хүртээл болоогүй аливаа мэдээллийг удирдлагын зөвшөөрөлгүйгээр бусдад тараах, байгууллагаас явуулж буй бодлогын арга хэмжээг албан хаагчийн хувьд гүйвуулан шүүмжлэх, эсхүл өөрийн санаа санаачилга мэтээр ярьж сайрхахаас зайлсхийх.

**5.1.3. Төрт ёс, түүх, соёлынхoo уламжлалыг нандигнан өвлөж, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:**

5.1.3.а.Төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;

5.1.3.б. Албан тушаалын бүрэн эрхээ ашиглан бусдыг дарамтлах, эрхшээлдээ байлгах, хавчин гадуурхахгүй байх; "

5.1.3.в: Жендерийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамт үзүүлэхээс ангид байх;

5.1.3.г. Төрт ёс, түүх, соёлын өв уламжлалаас суралцах, Монголын ард түмний соёл, зан үйлийг хүндэтгэх;

5.1.4.д. Ажлын бус цагаар байгууллагын нэр хүндэд харшлах аливаа зохисгүй үйлдэл гаргахгүй байх, цахим орчинд санал бодлоо илэрхийлэхдээ уг хэллэг, агуулгын хувьд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлах;

5.1.4.е. Ажлын байранд ажил хэрэгч албаны хувцас өмсөх.

**5.1.4. Ард түмэндээ чин сэтгэлээс үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх ёс зүйн хэм хэмжээний хүрээнд;**

5.1.4.а. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, үйлчлүүлэгчтэй эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, төрийн үйлчилгээг чирэгдэл,

ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх;

5.1.4.б. Төрийн албаны нэр хүндийг ямагт дээдэлж, түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх;

5.1.4.в. Гадаад улсад албан томилолтоор ажиллах хугацаандаа дипломат ёс жаягийг чанд баримталж, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх;

5.1.4.г. Гадаадад зорчихдоо мөрийтэй тоглоом (казино) тоглож, энэ төрлийн үйлчилгээний газраар үйлчлүүлэхгүй байх;

5.1.4.д. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажлын байрандаа согтууруулах ундаа, хэрэглэх, этгээд байдлаар хувцаслах, бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэж, олон нийтийн газарт мөрдөх дэг журмыг сахих;

5.1.4.е. төрийн байгууллагаас явуулж байгаа бодлого, хууль ёсны үйл ажиллагааг үл эсэргүүцэх, үндэслэлгүй мэдээ, мэдээлэл тараахгүй байх.

**5.1.5. Албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээх ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:**

5.1.5.а. Албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд бүрэн хариуцах;

5.1.5.б. Ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд үйлдэлдээ дүгнэлт хийж, албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр татгалзах хүртэл хариуцлага хүлээх чадвартай байх;

5.1.5.в. Ажил үүрэгтэй холбоотой гаргасан дүгнэлт, акт, албан шаардлага, албан бичиг, тайлан мэдээ, тоо баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах;

5.1.5.г. Ажлын /улсын байцаагчийн/ үнэмлэх тэмдгээ хууль бусаар ашиглах, барьцаалах, хувилах, албаны бус ажилд ашиглахыг хориглох;

5.1.5. д. Гарын үсэг зурж баталгаажуулсан акт, дүгнэлт, албан шаардлага, судалгаа, тайлан мэдээ, бусад албан бичиг, баримтыг засварлах, өөрчлөхийг хориглох;

5.1.5.е. Хийсэн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэдээд мэдээлэл, судалгаа, тайлан, биелэлт, боловсруулсан баримт бичиг, гаргасан шийдвэрийнхээ эцсийн хариуцлагыг хүлээх;

5.1.5.ё. Бусад албан хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардах, үүрэг даалгавар өгөхийг хориглох;

5.1.5.ж. Баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг хангах, хувь хүн байгууллагын нууцыг хамгаалах зорилгоор албан өрөөндөө гадны хүн үлдээхээс зайлсхийх.

**5.1.6. Албан үүргээ гүйцэтгэхдээ улс төрийн хувьд төвийг сахиж, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа нөлөөллөөс ангид байх ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:**

5.1.6.а. Төрийн алба хаах хугацаанд улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөнөөс аливаа үүрэг хүлээхгүй, нөлөөлөлд автахгүй байх;

5.1.6.б. Төрийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцох, мэдээ, мэдээлэл тараахгүй байх;

5.1.6.в. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх.

**5.1.7. Захирах, захирагдах ёсыг сахин биелүүлэх ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:**

- 5.1.7.а. Удирдлагадаа байгаа албан хаагчдын өмнө нэр хүнд, ажил хэргийн улгэр жишээг үзүүлэх;
- 5.1.7.б. Хамт олны дотор ажил хэрэгч сэтгэл зүйн уур амьсгалыг бүрдүүлэх;
- 5.1.7.в. Хамт олны дунд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх, зөрчлийг зохицуулах;
- 5.1.7.г. Авлигын орчин үүсэхээс урьдчилан сэргийлэх;
- 5.1.7.д. Удирдлагадаа байгаа ажилтныг улс төрийн үйл ажиллагаанд татагдан орохоос сэргийлэх;
- 5.1.7.е. Ёс зүйн хэм хэмжээ зөрчигдөхөөс сэргийлэх, ёс зүйн сургалт зохион байгуулах;
- 5.1.7.ё. Удирдлагадаа байгаа албан хаагчийг айлган сүрдүүлэх, доромжлох, хясан боогдуулах зэргээр албаны хэвийн харилцааг алдагдуулах, хууль бус үүрэг даалгавар өгөхгүй байх;
- 5.1.7.ж. Албан харилцаанд хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдал, хувийн болон гэр бүлийн нууц, нэр төр, алдар хүндийг эрхэмлэх зарчим баримтлах;
- 5.1.7.и. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх;
- 5.1.7.к. Албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахыг цээрлэх;
- 5.1.7.и. Удирдлагадаа байгаа төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг шударгаар үнэлэх, ялгаварлан харилцах, ажлын гүйцэтгэлийг үндэслэлгүйгээр үгүйсэх, шүүмжлэхгүй байх;
- 5.1.7.й. Удирдах албан тушаалтан болон албан хаагч нь бусад ажилтнаа ялгаварлан гадуурхах, дээрэнгүй харилцах, гутаан доромжлох, баримт нотолгоогүй нэр хүндэд халдсан худал яриа тараахгүй байх, харилцан бие биеэ хүндэлсэн ажиллах орчныг бүрдүүлэх.

**Зургаа. Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага**

6.1. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралт “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” болон энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн удирдах албан тушаалтан болон албан хаагчийн үйлдэл, эс үйлдэл нь тогтоогдсон тохиолдолд түүнд ёс зүйн хариуцлага болон сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын  
2023 оны 04 дүгээр сарын 08 -ны өдрийн  
33 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Нийслэлийн Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч ( цаашид “төрийн албан хаагч” гэх)-ийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоож хэвшүүлэх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол мэдээллийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын ёс зүйн зөвлөлийн хурал /цаашид хурал гэх/ хийхэд энэхүү журмыг баримтална.

1.3. Ёс зүйн зөвлөл нь үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Хөдөлмөрийн тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтооолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” болон энэхүү журмыг мөрдөж ажиллана.

**Хоёр. Ёс зүйн зөрчлийн тухай мэдээллийг хүлээж авах, хянан шийдвэрлэх ажиллагаа:**

2.1. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн зөрчлийг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх ёс зүйн зөвлөл хянан шийдвэрлэнэ.

2.2. Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн гомдол, мэдээлэл, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн болон тухайн байгууллагын дотоод хяналтаар илэрсэн мэдээ, баримт нь шалгалт явуулах үндэслэл болно.

2.3. Тухайн албан хаагчийн дээд шатны албан тушаалтан, эсхүл уг байгууллагад дотоод хяналт, шалгалт хариуцсан нэгж, албан тушаалтан ажилладаг бол тэрхүү нэгж, албан тушаалтан мэдээллийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор дараах журмын дагуу шалгалт явуулна:

2.3.1. Гомдол, мэдээлэлд холбогдсон албан хаагч болон гомдол, мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдгээрийн тайлбар, саналыг сонсож тэмдэглэл хөтлөх;

2.3.2. Шаардлагатай гэж үзвэл бусад байгууллагаас баримт бичиг, тайлбар, бусад лавлагаа материалыг гаргуулж авах;

2.3.3. Харьяалах нэгжийн удирдлага, албан хаагчидтай уулзаж, шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулах.

2.4. Гомдол, мэдээллийг шалгах хугацааг шаардлагатай бол байгууллагын удирдлага нэг удаа 14 хоногоор сунгаж болно.

2.5. Төрийн албан хаагч энэ дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг зөрчсөн нь сахилгын зөрчлийн шинжтэй болох нь шалгалтаар тогтоогдвол шалгалтын дүнг байгууллагын удирдлагад танилцуулан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлд хүргүүлнэ.

**Гурав. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын ёс зүйн зөвлөлийн зохион байгуулалт:**

3.1. Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах эрх бүхий Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл (цаашид “Ёс зүйн зөвлөл” гэх) нь Нийслэлийн эрүүл мэндийн газрын дэргэд ажиллана.

3.2. Ёс зүйн зөвлөлийн гишүүдийн тоог тухайн байгууллагын төрийн албан хаагчдын тоог харгалзан 5 гишүүнтэй байхаар тогтоож, төрийн албан хаагчдын саналыг үндэслэн томилох эрх бүхий албан тушаалтан гурван жилийн хугацаагаар томилно. Зөвлөлийн ажиллах журмыг томилох эрх бүхий албан тушаалтан батална.

3.3. Ёс зүйн зөвлөл нь төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг шалгаж, ирүүлсэн танилцуулга, материалыг гишүүдийн ердийн олонхын ирцтэй хуралдан хэлэлцэж, шалгалтын дүнг үндэслэлтэй гэж үзвэл зөрчлийн шинж байдлыг харгалзан, зөрчил гаргагчид хариуцлага хүлээлгэх тогтоол гаргана.

3.4. Ёс зүйн зөвлөлийн тогтоолоор энэ дүрмийн 5.2.1-д заасан хариуцлага хүлээлгэсэн тохиолдолд училал гүйх хэлбэрийг тодорхойлсон байна.

3.5. Ёс зүйн зөвлөлийн хуралдаанд гомдол, мэдээллийг шалгасан албан тушаалтан болон ёс зүйн зөрчилд холбогдсон албан хаагчийг биечлэн оролцуулж тайлбарыг сонсож, асуулт тавьж, хариулт авч болно.

3.6. Ёс зүйн зөвлөлийн тогтоолыг зөрчил гаргасан албан хаагчид танилцуулна.

3.7. Ёс зүйн зөвлөл тухайн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл гомдол, мэдээлэл гаргасан иргэн, байгууллагад энэ тухай бичгээр хариу өгнө.

3.8. Ёс зүй зөвлөл нь байгуулагдсанаас хойших хугацаан дахь төрийн албан хаагчтай холбоотой санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.

3.9. Байгууллагын удирдлага ёс зүйн зөвлөлийн ажилд дэмжлэг үзүүлнэ.

#### **Дөрөв. Зөвлөлийн хурлын дэг:**

4.1. Ёс зүйн хорооны хуралдааны товыг ёс зүйн хорооны дарга тодорхойлж, хэлэлцэх асуудлыг нарийн бичгийн дарга хорооны гишүүдэд 7-оос доошгүй хоногийн өмнө мэдээлнэ.

4.2 Зөвлөлийн дарга болон гишүүд хурлын цагийг баримталж хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд хуралд заавал оролцох. /Хүндэтгэн үзэх шалтгаан гэдэгт ээлжийн амралтай, өвчтэй, чөлөөтэй байхыг ойлгоно/ үүрэгтэй.

4.2. Зөвлөлийн дарга хурлын дэгийг сахиулж, удирдах, түүнийг зөрчсөн гишүүд, албан хаагчид дэг биелүүлэхийг шаардах, хүсэлт гаргасан дарааллын дагуу асуулт асуух, санал хэлэх зөвшөөрөл олгох.

4.3. Зөвлөлийн хурлын нарийн бичгийн дарга нь хурлыг бэлтгэл хангуулах, ирцийг хангуулж, бүртгэх, хурлын тэмдэглэл хөтөлж, албажуулах.

4.4 Зөвлөлийн хурлаас хурлын шийдвэр, тогтоол гаргах.

**Тав. Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага:**

5.1. Холбогдох хууль, байгууллагын ёс зүйн дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг төрийн захиргааны болон үйлчилгээний ажилтан нь зөрчсөн үйлдэл, эс үйлдэл нь түүнд сахилгын шийтгэл ноогдуулах үндэслэл болно.

5.2 Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төрийн албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан ёс зүйн дараах хариуцлага хүлээлгэнэ:

5.2.1. училал гүйхыг үүрэг болгох;

5.2.2. сануулах;

5.3. Төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд үйлдэлдээ дүгнэлт хийж дагуу сайн дураараа албан тушаалаас чөлөөлөгдөх нь ёс зүйн хариуцлага хүлээсэнд тооцогдоно.

5.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

5.5. Сахилын шийтгэлийг Төрийн албаны болон Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу газрын даргын тушаалаар оногдуулна. Сахилгын шийтгэл оногдуулахдаа ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг урьдчилан тогтоосон байна.

5.6. Сахилгын шийтгэл ногдуулсан тухай тушаалыг тухайн албан хаагчийн хувийн хэрэгт хавсаргах бөгөөд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу олон нийтэд мэдээлнэ.

Хавсралт 1.

**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ЁС ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны..... сарын...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Хавсралт 2.

**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ЁС ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР**

2023 оны..... сарын....-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Хавсралт 3.

**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ЁС ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны..... сарын....-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот